

# Бромгексин 8 мг

Бүртгэлийн дугаар:00700

## НАЙРЛАГА:

Үйлчлэгч бодис: Бромгексины гидрохлорид 8 мг;

Туслах бодисууд: лактоз моногидрат, улаан буудайн цардуул, желатин, магнийн стеарат.

## ФАРМАКОЛОГИЙН ҮЙЛДЭЛ:

Бромгексин цэр шингэлэх, ховхлох үйлдэл үзүүлнэ.

Бэлдмэл нь *Adhatoda vasica* хэмээх энэтхэгийн ургамлаас гаргаж авсан *Vasicine* алкалоидтай химийн бүтцээрээ төстэй нийлэг бэлдмэл юм. Бронхын шүүрлийн зуурмаг чанарыг шингэрүүлж, цэр аяндаа болон ханиалгаар ховхрох нөхцөлийг бүрдүүлнэ. Гуурсан хоолойн салс бүрхүүлийг гэмтээхгүй. Бага зэрэг ханиалга дарах үйлчилгээ үзүүлнэ.

## ХЭРЭГЛЭХ ЗААЛТ:

*Эмчийн заавраар хэрэглэнэ.*

Ховхроход бэрхшээлтэй өтгөн цэр дагалдсан гуурсан хоолой, уушгины үрэвсэлт өвчнүүд (трахеобронхит, агчилт бронхит, уушгины үрэвсэл, бронхэктази, архаг бөглөрөлт бронхит, уушгины сүрьеэ, пневмокониоз)-ийн үед хэрэглэнэ.

## ЦЭЭРЛЭЛТ:

Бэлдмэлд мэдрэг хүмүүс, хүнд явцтай бөөрний дутагдлын үед хэрэглэхийг цээрлэнэ.

## ГАЖ НӨЛӨӨ:

*Бэлдмэлийг хэрэглэж байх явцад үндсэн өвчинтэй холбоогүй зовиур илэрвэл эмчдээ хандах хэрэгтэй!*

Бромгексин зохимж сайтай боловч хааяа харшлын урвал, ходоод гэдэсний замын талаас зовиур илэрч болно. Эрхтэн тогтолцооны талаас дараах гаж нөлөө илэрч болзошгүй:

- арьс, салст бүрхүүл- (чонон хөрвөс, салстын үлхий)
- мэдрэлийн тогтолцоо- толгой эргэх, толгой өвдөх
- ходоод гэдэсний зам- дотор муухайрах, бөөлжих, маш ховор тохиолдолд ходоод гэдэсний шархлаа үүсэх
- дархлалын тогтолцоо-харшлын урвал (хаван), халуурах

## ТУН ХЭТЭРСНИЙ УЛМААС ИЛРЭХ НӨЛӨӨ:

Тун хэтэрсэн тохиолдол илрээгүй.

## БОЛГООМЖЛОЛ БА УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ:

Элэгний үйл ажиллагааны идэвхийг тодорхойлдог биохимийн шинжилгээний үзүүлэлтүүдийг өөрчилдөг тул БРОМГЕКСИН хэрэглэж байгаа тухайгаа эмчдээ урьдчилан мэдэгдэх хэрэгтэй. Идэгдмэл шархлаатай хүнд ходоодны салстыг гэмтээж болох тул маш болгоомжтой хэрэглэнэ.

*Бэлдмэлийг хэрэглэж байгаа үед уух шингэний хэмжээ их байвал зохино.*

## ЭМИЙН ХАРИЛЦАН ҮЙЛЧЛЭЛ:

*Бромгексиныг бусад эмтэй хамт хэрэглэх шаардлагатай тохиолдолд эмчийн зөвлөгөө авна.*

Уушгины өвчнийг эмчлэх бусад эмүүдтэй хамт хэрэглэхэд тохиромжтой. Бэлдмэлийг шаардлагатай үед бактерийн эсрэг, бронх өргөсгөх, зүрх судасны болон бусад эмүүдтэй хавсарч хэрэглэж болно.

Бромгексиныг цэрэн дэх эритромицин, цефалексин, окситетрациклин зэрэг зарим антибиотикийн концентрацийг ихэсгэдэг тул хамт хэрэглэнэ. Ийм эмчилгээ уушгины архаг өвчний үед настай хүмүүст өндөр үр дүнтэй байдаг.

Бромгексиныг кодеин болон ханиалгын рефлексийг дарангуйлдаг бусад эмүүдтэй хамт хэрэглэхгүй. Учир нь цэрний шингэрч ховхрох нь удааширдаг.

### **ЖИРЭМСЭН БА ХӨХҮҮЛ ҮЕИЙН ХЭРЭГЛЭЭ:**

Бэлдмэлийг жирэмсэн ба хөхүүл үед хэрэглэхгүй. Бэлдмэл хөхний сүүгээр ялгардаг.

### **АВТОМАШИН ЖОЛООДОХ, ТЕХНИКТЭЙ АЖИЛЛАХАД ЭМИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ:**

Анхаарал төвлөрөлт, хөдөлгөөний идэвх, рефлексүүдэд сөрөг нөлөө үзүүлдэг тухай хэвлэлд бичигдээгүй байна.

### **ХЭРЭГЛЭХ АРГА, ТУН:**

*Эмчилгээний хугацаа болон эмийн тунг эмч тогтооно.*

Бэлдмэлийг хоол идэх хугацаанаас хамааралгүйгээр хоолны өмнө болон дараа ууж хэрэглэнэ.

Насанд хүрэгсэд ба 14-с дээш насны хүүхдэд эмчилгээний дундаж тун 1-2 шахмал буюу 8 мг-аар хоногт 3-4 удаа ууна.

6-14 насны хүүхдэд 1/2 шахмалаар хоногт 3 удаа, 3-6 насны хүүхдэд 1/2 шахмалаар хоногт 2 удаа хэрэглэнэ.

Архаг өвчнүүдийн үед эмчилгээний үргэлжлэх хугацаа насанд хүрэгсдэд 3-5 долоо хоног, хүүхдэд 2-3 долоо хоног байна.

### **ЭМИЙН ХЭЛБЭР, САВЛАЛТ:**

8 мг шахмал хэлбэрээр хайрцагтаа 20 ширхгээр

8 мг шахмал хэлбэрээр хайрцагтаа 40 ширхгээр тус тус савлагдана.

### **ХАДГАЛАЛТ:**

25°C-с доош хэмд хуурай газар, гэрлээс хамгаалж хадгална. ХҮҮХЭД ХҮРЭХГҮЙ ГАЗАР ХАДГАЛНА!

### **ЭМИЙГ ОЛГОХ ЖУРАМ:**

Жороор олгоно.

### **ХАДГАЛАХ ХУГАЦАА:**

Үйлдвэрлэснээс хойш 5 (тав) жил. Савлалтан дээр тэмдэглэсэн хадгалах хугацаа дууссанаас хойш хэрэглэж болохгүй!

Үйлдвэрлэгч:  
Балканфарм –Дупница АД, ул. Самоковское шоссе, 3,2600 Дупница, Болгария, тел:  
(+359701) 58196, факс (+359701)58555.

